



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 06 сарын 10 өдөр

Дугаар A/410.

Булган сум

Итгэмжлэгдсэн төлөөлөгч томилох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.2, 27.3 дахь хэсгийг тус тус үндэслэн **ЗАХИРАМЖЛАХ** нь:

1."Мөнхсартуул өргөө" ХХК-ийн нэхэмжлэлтэй аймгийн Засаг даргад холбогдох захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хариуцагчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга Бадарчийн Одхүүг томилсугай.

2.Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.1, 28.2.2, 28.2.3, 28.2.4, 28.2.6 дахь зүйлд заасан бүрэн эрхийг хэрэгжүүлэн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцож, үр дүнг мэдээлэхийг итгэмжлэгдсэн төлөөлөгч (Б.Одхүү)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Д.ПҮРЭВ-ОЧИР

